



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС УЧИРСАН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙН ТУХАЙ ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР
2024

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	2
ТАЛАРХАЛ	3
СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ДҮГНЭЛТ	4
СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ЗӨВЛӨМЖ	5
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	
• Бэлтгэл ажил	8
• Судалгааны зорилго	8
• Судалгааны арга	8
• Судалгааны хамрах хүрээ	9
• Судалгааны зорилтот газар	9
ХОЁР. СУДАЛГААНЫ ДҮН	
• Хэнтий аймгийн Мөрөн сумын судалгааны дүн	10
• Дорнод аймгийн Баяндун сумын судалгааны дүн	19
• Сүхбаатар аймгийн Дарьганга сумын судалгааны дүн	26

ТОВЧИЛСОН ҮГС

ХЭХТ	–	Хүний Эрх Хөгжил Төв
ГЯ	–	Ганцаарчилсан ярилцлага
ИНБ	–	Иргэний нийгмийн байгууллага
ЗГ	–	Засгийн газар
ИТХ	–	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХБХ	–	Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбоо
МУ	–	Монгол Улс
УАӨ	–	Уур амьсгалын өөрчлөлт
ХЗДХЯ	–	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХААГ	–	Хүнс Хөдөө Аж Ахуйн Газар
ХБИХ	–	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
ФБЯ	–	Фокус бүлгийн ярилцлага
ЭЗНСЭС	–	Эдийн засаг нийгэм соёлын эрхийн сүлжээ
ТББ	–	Төрийн бус байгууллага
ЗДТГ	–	Засаг даргын Тамгын газар

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн сүлжээ (ЭЗНСЭС) олон улсын байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлсэн “Уур амьсгалын өөрчлөлтийн хохирол, хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА” төслийн хүрээнд Хүний Эрх Хөгжил Төв ТББ–тай хамтран ажилласан Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Хэнтий аймгийн Мөрөн сумын Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоодын гишүүдэд талархал илэрхийлье.

“Уур амьсгалын өөрчлөлтийн хохирол, хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА”–ны асуулга, ярилцлагад идэвхтэй оролцож, уур амьсгалын өөрчлөлттэй нүүр тулсан сорилтуудаа ярилцсан ахмад малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ногоочид, залуу малчдын төлөөллүүдэд талархаж байна.

Энэхүү судалгаанд цаг зав гарган ярилцаж, шаардлагатай мэдээллээр хангасан гурван сумын засаг захиргааны удирдлагууд, мэргэжилтнүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт баярласнаа илэрхийлж байна.

Тус судалгааны фокус бүлгийн нэгдсэн ярилцлагыг зохион байгуулахад өрөө байраар хангаж өгсөн Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Хэнтий аймгийн Мөрөн сум, Дорнод аймгийн Баяндун сумын захиргаа болон техник хэрэгслээр ханган хамтарч ажилласан. Дарьганга сум дахь Байгалийн Цогцолборт Газрын Хамгаалалтын Захиргаа болон өөрсдийн гэрэл зургийн аппарат, тоног төхөөрөмжийг ашиглуулсан “Байгаль дэлхий” бүлгийн гишүүдэд баярлалаа.

Судалгааны багийн гишүүдийг сургах, судалгааны тайланг боловсруулан бичихэд мэргэжлийн зөвлөгөө өгч төслийг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн сүлжээний ажилтнууд болон Франческа Феруглио, Том Вийрачат төслийн явцад орон нутгийн гишүүдийн хүсэлтээр цахим орчны аюулгүй байдлын сэдвээр сургалт зохион байгуулсан Ванесса Кория Кастилла нарт чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

ХЭХТ–ийн Хамт олон

СУДАЛГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ) ТББ нь Эдийн засаг нийгэм соёлын эрхийн Сүлжээ олон улсын байгууллагын техник, арга зүйн дэмжлэгээр Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Хэнтий аймгийн Мөрөн сум дахь ХЭХТ–ийн харьяа Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоотой хамтран “Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хохирол, хор уршгийн тухай “ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА” төслийг 2023 оноос эхлэн хэрэгжүүлээ.

Төслийн зорилго:

- Уур амьсгалын өөрчлөлтөөс малчид, мал бүхий иргэд, хүнсний ногоо тариалагчдад тулгамдсан асуудлыг тодорхойлох,
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах, урьдчилан сэргийлэх зохистой арга хэмжээ авах тухай талуудын ойлголтыг бэхжүүлэх,
- Орон нутгийн захиргаатай хамтран ажиллах орон нутгийн иргэдийн судалгааны чадавхийг хөгжүүлэхэд оршив.

ХЭХТ–ийн харьяа Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоо (МХБХ)–ны судалгааны багийн гишүүд орон нутагтаа ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААГ үр дүнтэй хэрэгжүүлж, судалгааны дүгнэлт зөвлөмжийг олон талын төлөөллийн оролцоотой нийтийн хэлэлцүүлэгт танилцуулан сумдаа тулгамдсан чухал асуудлыг хөндөж ярилцлаа.

Цаг агаар, байгаль орчин, байгалийн нөөцөд гарч буй өөрчлөлтийн нөлөө цаашид ч урт хугацаанд үргэлжлэх сорилт тулгарч байгааг дэлхийн уур амьсгалын дулаарлаас үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдэл илхэн харуулсаар байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны үр дүн зөвхөн малчид ногоочдын хүчин чармайлт, дадал чадвараас хамаараад зогсохгүй Үндэсний хэмжээний хөтөлбөр, бодлого зохицуулалт болон орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтээс ихээхэн хамааралтай болох тухай ойлголт орон нутгийн иргэдийн дунд түгээхэд энэ судалгааны ач холбогдол оршив.

Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Хэнтий аймгийн Мөрөн сумнд иргэд манлайлан хийсэн гурван судалгааны дүгнэлт дээр үндэслэн судалгааны гурван багийн ахлагч нартай хамтран Хүний эрх хөгжил төвийн баг нэгтгэсэн дүгнэлтийг боловсруулав.

I. Судалгааны асуулгын үр дүн:

1. УАӨ-ийн улмаас цаг уурын гамшигт үзэгдэл ган, зуд, үер, шуурга, гал түймэр зэрэг гамшигт үзэгдлийн давтамж ойртож цар хүрээ нэмэгдэж байна. 2024 оны зудаас болж хорогдсон мал, утсан ургацын тоо хэмжээ, шалтгааны тухай судалгаанд оролцогчид өөрсдийн амьдралд тохиолдсон бодит жишээн дээр мэдээллээ хуваалцав.

- Дорнод аймаг Баяндун сум: Зуднаар сумын хэмжээнд нийт хорогдсон мал 4063, үүнээс адуу 153; үхэр 713; хонь 1781; ямаа 1380 тус тус хорогдсон ба энэ нь өмнөх жилийн хорогдолтой харьцуулахад 2 дахин өссөн байна. Үүнийг их цас орж, цочир хүйтрэл болсонтой холбож тайлбарлажээ.
- Сүхбаатар аймаг Дарьганга сум: Дарьганга сумнд 2024 оны зудаар нийт 90,000 толгой мал хорогдсон ба судалгааны асуулгад оролцогчдоос 77 хүн нийт 14428 бод, бог мал алдсан байна. Мөн 700кг төмс, 350кг байцаа, 500кг лууван, 160кг манжин, 280кг сонгино, 180кг саримс) ургац алдсан. Шалтгаан нь цочир хүйтрэл, цасан шуурга, аадар бороо зэрэг байгалийн гамшигт үзэгдэл гэж хариулжээ.
- Хэнтий аймаг Мөрөн сум: Судалгаанд оролцогчдын 18 нь малын хорогдол, 32 нь ургац алдах хохирол амсаж, 11 нь эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хор уршиг үзүүлсэн гэж хариулжээ. Сумын хэмжээнд 2024 оны зудаар бог мал – 3331; бод мал 925 тус тус хорогдсоны шалтгаан нь цочир хүйтрэл, их цас орсонтой холбоотой байна.

2. Зудаар их хохирол, хор уршиг учирч байгаа боловч түүнийг барагдуулах талаар хаана хэнд хандахаа мэддэггүй, мэдээллээр дутмаг байдаг байна.

3. УАӨ-ийн тухай МУ-ын бодлого хууль тогтоомжийн талаар мэдэхгүй, мэдээлэл авах хэрэгцээ байна” гэж оролцогчдын дийлэнх үзжээ.

4. УАӨ-ийн нөлөөг бууруулах, сэргийлэх зорилгоор сум орон нутагт хэрэгжүүлдэг бодлого, төлөвлөгөө байдаг, түүнд иргэд оролцдог гэж орон нутгийн засаг захиргааны хүмүүстэй хийсэн ярилцлагад дурдсан байна. Гэвч энэ талаар судалгаанд хамрагдсан малчид, өрхийн тариалан эрхлэгчид ямар ч мэдээлэлгүй байв.

II. Бодлогын хэрэгжилт, зохицуулалт орон нутгийн түвшинд:

- УАӨ-ын тухай МУ-ын бодлого хууль тогтоомжийн талаар “мэдээлэлгүй, мэдээлэл авах хэрэгцээ байна” гэж оролцогчдын дийлэнх үзсэн. Энэ нь малчид, өрхийн тариалан эрхлэгчид, иргэдийн мэдэх эрхийг хүндэтгэн үзэж, мэдээллийн хүртээмжийг сайжруулахын чухлыг илтгэн харуулж байна. Нөгөө талаар, УАӨ-д дасан зохицох төрийн бодлого, зохицуулалт орон нутгийн иргэдэд хүрч үр дүнгээ өгөхгүй байна.
- Сумын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд УАӨ-ийн нөлөөг бууруулах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг иргэдээр ил тодоор хэлэлцүүлж, мэдээллийг хүртээмжтэй хүргэж байхыг санал болгосон байна.
- УАӨ-өөс учирсан хохирлын хэмжээг тооцдог, мэдээлдэг чадвар, дадалд сургах, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй ажиллах, энэ талаарх иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэхэд чиглэсэн орон нутгийн захиргааны санаачилга дутагдаж байна.
- Орон нутагт бэлчээр сэлгэх, зүй зохистой ашиглах, төлөвлөх оновчтой арга хэмжээ хэрэгжүүлэхэд анхаарч үр дүнтэй ажиллаж чадахгүй байна. Өөр сумын малыг олноор оторлуулж байгаагаас бэлчээр талхлагдан бэлчээрийн хомсдол үүсэж малын хорогдолд хүргэж байна.

III. Бүлгийн ярилцлагаар оролцогчдын дэвшүүлсэн чухал санаанууд:

- Судалгаанд оролцсон хүмүүсийн 95 хувь нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөмхий байдлыг бууруулах, дасан зохицох, байгалийн гамшигийг даван туулах дадал, чадвараа нэмэгдүүлэх талаар мэдээлэл хангалтгүй байгааг тэмдэглэж сургалт авахыг хүссэн.
- Малчид, өрхийн тариалан эрхлэгчид хохирлоо тооцож үнэлдэггүй байдал нийтлэг байна. Үүнд амьдралын хэвшмэл ойлголт нөлөөлж байгаа нь ажиглагдсан. Малчид, өрхийн тариалан эрхлэгчид хохирлоо тооцож

үздэггүйгээс санхүүгийн дэмжлэг авах талаар хөөцөлддөггүй. Үүнд хайхрах газар, байгууллага байдаггүй гэсэн итгэл үнэмшил нөлөөлж байна. Эдийн засгийн алдагдлаа нөхөх талаар төлөвлөдөггүй байна.

- Малчид тогтвортой амьжиргааг дэмжих эх үүсвэрийг нэмэгдүүлэх сонирхол их байна. Малаас гарах түүхий эд, бүтээгдэхүүнийг үнэд хүргэж борлуулах, сур элдэх, аргамжаа, хазаар хийх, олом гүрэх, өөхөө ашиглаад саван хийх, цагаан идээгээ боловсруулах, унага даага сургах, эмээл хазаар хийх гэх мэт. Ингэснээр малчдын орлого нэмэгдэж, олсон орлогоороо өвс тэжээлээ өөрсдөө авдаг болно гэжээ.
- Залуу малчдын халааг бэлтгэх талаар ахмад малчдын санаа их зовних болсон. Энэ асуудалд орон нутгийн захиргаа анхаарч, залуучууд руу чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлж, залуучуудад малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, гэр үйлдвэрлэл эрхлэх арга замыг зааж сургах хэрэгтэй гэж үзэж байна.
- Ам бүл цөөхөн, ганц нэгээрээ өвөлждөг малчид хоорондоо хот айл болж, хоршиж ажиллавал байгалийн гамшгийг эрсдэлгүй даван туулах боломжтой юм гэдгийг зарим малчид хэлж байлаа.

СУДАЛГААНЫ НЭГТГЭСЭН ЗӨВЛӨМЖ

Дорнод аймгийн Баяндун сум, Сүхбаатар аймгийн Дарьганга сум, Хэнтий аймгийн Мөрөн сумнд иргэд манлайлан хийсэн гурван судалгааны зөвлөмжийг судалгааны багийн ахлагч нартай хамтран Хүний эрх хөгжил төвийн баг нэгтгэн боловсруулав.

I. Үндэсний бодлогыг Орон нутгийн хэрэгцээтэй уялдуулан хэрэгжүүлэх:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд (дунд хугацааны стратегийн 2 дугаар үе шат 2020–2025) орон нутгийн захиргаа, иргэдийн оролцоог хангах.
- Гамшгаас хамгаалах тухай хууль, орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний талаар нэгдсэн ойлголтыг бүх сумдад өгч, эрсдэлийг бууруулахад үр дүн гаргах.
- Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ–ын Хүрээ Конвенц болон уур амьсгалын өөрчлөлтийн талаар эрдэмтдийн хийсэн судалгаа, УАӨ–ийн үзүүлж буй нөлөө, учирсан эрсдэлийг сааруулах үр дүнтэй арга хэмжээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэх талаар малчид, өрхийн тариалан эрхлэгчид ойлгомжтой хялбараар мэдээлж, төлөвлөгөөг бодитой оновчтой гаргаж хэлэлцүүлэхэд ашиглах.
- НҮБ–ын Хөгжлийн Хөтөлбөр, Уур амьсгалын ногоон сан, Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газартай хамтран мал аж ахуйн салбарын үр ашиг, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй ямар төсөл хөтөлбөр байгааг судалж, малаас гарах түүхий эдийг боловсруулах чадавхыг нэмэгдүүлэх, малын чанарыг сайжруулах, улмаар малын хөлийн талхагдлаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, байгаль орчинд эерэг нөлөөлөл үзүүлэх, малчдын амьжиргааг тогтвортой байлгаж, мал бол үндэсний баялаг тул хамгаалалтыг хангахад анхаарах.
- Бэлчээрийн даацын судалгаатай ажиллаж, өвөлжөө хаваржаа, зундаа нутаг сэлгэж байх бодлого, төлөвлөгөө хэрэгжүүлэх. Бэлчээрийн зохистой ашиглалтын тухай сайн туршлагыг дэлгэрүүлж, ахмад туршлагатай малчид болон бэлчээрийн судалгаа хийсэн эрдэмтдийн зөвлөгөөг авч хамтран ажиллах.
- Монгол Улсын шинээр батлагдсан малчны нийгмийн хамгааллын талаарх хуулиудыг сурталчилж таниулах, хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах.
- Залуу халаа малчдыг чадваржуулах төсөл хөтөлбөрт хамруулах талаар төрөөс бодлогоор дэмжих.

II. Орон нутгийн бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах:

- УАӨ–д дасан зохицох талаар урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг шат дараатай үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэх.
- УАӨ–ийн дасан зохицох МУ–ын бодлого хууль тогтоомжийн талаар малчид, өрхийн тариалан эрхлэгчид, иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах. ТББ–ыг чадавхжуулан хамтарч ажиллах замаар төрийн бодлогыг иргэдэд үр дүнтэй хүргэх.
- Орон нутгийн засаг захиргаа бэлчээрийн даацад нийцүүлэн бэлчээрийг зүй зохистой ашиглах талаар малчдаар хэлэлцүүлж, бэлчээрийн экологийн чадавхад суурилсан, зун, намар бэлчээрийг сэлгэж, өнжөөдөг, малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэх оновчтой шийдвэрт хүрч ажиллах.

- Аймгийн Засаг Даргын захирамжаар гадны мал оруулахгүй байх талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд хориглосон. Орон нутгийн захиргаа, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах. /Цөлжилт болон бэлчээрийн талхагдлаас хамгаална/
- Малын нийт хорогдол 6 хувиас дээш байх босгыг багасгах эсвэл даатгал хийлгэсэн малчин бүр хорогдлын хэмжээгээр нөхөн төлбөр авдаг болох өөрчлөлтийг төр, даатгалын байгууллагуудтай хамтарч хийх
- Гамшгаас хамгаалах “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх санхүүжилтийн (тухайн жилтийн орон нутгийн төсвийн 1 хувь, хуулийн этгээдийн зардлын 1.5 хувь) зарцуулалт, үнэлгээг ил тод болгон үр дүнг дээшлүүлэх. Санхүүжилтийг нэмэгдүүлэх өөр эх үүсвэрийг хайх.
- УАӨ-ийн нөлөөгөөр малчид, өрхийн тариалан эрхлэгчдэд учирсан хохирол, хор уршгийг барагдуулах бүх талын арга хэмжээг судалж, оновчтой нэвтрүүлэх.
- Цаг агаарын нөхцөл байдал хүндэрсэн үед малчдад үзүүлэх төрийн үйлчилгээн дэх хүнд суртлыг арилгах, нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг шуурхай авах.
- Сум багт, малчдад, өрхийн тариалан эрхлэгчдэд туулах чадвартай техникээр хангахад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, аж ахуй нэгжүүдтэй хамтын ажиллагааг бий болгох.
- Малчдаа эргэж тойрч малын тоо толгойд нийцүүлэн өвөлжилтийн бэлтгэлээ чанартай хангах талаар зөвлөж зохих дэмжлэгийг үзүүлэх.
- Хот айлын зарчмаар нэгдэж, хөдөлмөрөө хоршиж ажиллах талаар малчдын санаа бодлыг сонсож, өвөл хаврын зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.
- Малчдыг төсөл хөтөлбөрт хамруулах талаар орон нутгийн засаг захиргаа бодлогоор дэмжих. Жишээ нь: Малчдын амьжиргааны эх үүсвэрийг дэмжих зорилгоор “Малчдын өв соёлын өдөр”-ийг аялал жуулчлалын байгууллагуудтай хамтарч зохион байгуулдаг болох.
- Өвөлжилт хаваржилтын бэлтгэлийг чанартай сайн хангуулах, малчдын сайн туршлагауудыг нэвтрүүлэх, зөвлөгөө өгөх зэргээр бодитой арга хэмжээ авах.
- Залуу малчдын халааг бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх: Залуучуудад малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, гэр үйлдвэрлэл эрхлэх арга замыг зааж сургах. УИХ-ын орон нутгийг төлөөлж байгаа гишүүний дэмжлэгийг авах.
- Цас зуд зэрэг хүндэрсэн нөхцөлд багийн төвд хүний эмчийг байрлуулж ажиллуулах.

III. Малчдад:

1. УАӨ-д дасан зохицож мал аж ахуйгаа эрхлэх, амьжиргааны эх үүсвэрээ нэмэгдүүлэх талаар сургалт хөтөлбөрт хамрагдах, туршлага судлах.
2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар өөрөөсөө хамаарах бүхий л бололцоог дайчлан хувийн төлөвлөгөөгөө бодитой гаргаж дэмжлэг авч ажиллах. Үүнд:
 - Бэлчээрийн даац, газар зүйн байршилд тохирсон мал өсгөж, малынхаа тоо толгойг өсгөхөөс илүү чанартай сүргийн бүтцийг бий болгох боломжийг судалж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх.
 - Хот айлын зарчмаар нэгдэж, хөдөлмөрөө хоршиж ажиллах, малын тоо толгойд нийцүүлэн өвөлжилтийн бэлтгэлээ чанартай хангахад анхаарах.
 - Малчид хадлан тэжээлээ хангалттай нөөцөлж, зээлийн дарамтад орохгүй байх.
 - Туулах чадвартай техникийг худалдан авах, өвөлжилтийн бэлтгэл хангах үеэр шатахууныг нөөцлөх.
 - Өрхийн тогтвортой амьжиргааг дэмжих эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар хот айлаар ярилцаж, малаас гарах түүхий эд, бүтээгдэхүүнийг үнэд хүргэж борлуулах, орлого нэмэгдүүлэх хувийн төлөвлөгөөтэй ажиллах. Сургалтад хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлэх, орон нутгийн засаг захиргааны төлөвлөгөөтэй уялдуулах, дэмжлэг авах.
 - Өөрсдийн туршлагаа өвлүүлэх залуу малчдын халааг бэлтгэхэд анхаарч, үр хүүхдүүдээ төсөл хөтөлбөрт хамруулах: Залуучуудад малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, гэр үйлдвэрлэл эрхлэх арга замыг зааж сургах. Бүтээгдэхүүнээ сурталчлах ажлыг орон нутгийн засаг захиргааны төлөвлөгөөтэй уялдуулж дэмжүүлэх.

IV. Төрийн бус байгууллага (ТББ):

- ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААГ хийснээр орон нутгийн Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн гишүүд өөрсдөө судалгаа хийдэг чадварт суралцлаа. Судалгааны дүн, зөвлөмжийг олон улсын байгууллагад тайлагнахаас гадна төр засагт албан бичгээр танилцуулж, төрийн бодлого зохицуулалтад зохих шийдвэрийг тусгуулж ажиллах.
- Орон нутгийн МХБХ-ны гишүүдийг цаашид чадавхжуулах, судалгааны үр дүнг бодит ажил болгоход төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх чадварт сургаж чадавхжуулах.

- Малын Индексжүүлсэн Даатгалын системийг боловсронгуй болгох, хохирлын нөхөн төлбөрийг олгох шинэ боломж хувилбаруудыг сонгон судлах.
- Өрхийн тариалан эрхлэгчид ургацын даатгалын системийг оновчтой байдлаар шийдэх асуудалд мэргэжлийн байгууллагуудад нөлөөлж ажиллах.
- Амьжиргааны эх үүсвэргүй болсон малчдыг дэмжиж малжуулах, малчин өрхийн амьжиргааг тогтвортой байлгах өрхийн орлогын эх үүсвэрийг бий болгох талаар сум, орон нутгийн удирдлагад МАЛЧДЫН ЗӨВЛӨМЖ гаргах хүсэлтийг хүргүүлэх.
- Уур амьсгалын өөрчлөлтөд учирсан хор хохирлыг ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА”-ны кейс тохиолдол, зөвлөмжийг орон нутгийн засаг захиргааны төлөвлөгөөнд тусгуулж уялдуулахад анхаарах. УИХ-ын тойргоос нэр дэвшсэн гишүүдэд танилцуулж, хэрэгжүүлэхэд төсвийн дэмжлэг авах.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, урьдчилан сэргийлэх талаар шат дараатай хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаар олон нийтээр хэлэлцүүлдэг болоход нөлөөлөл үзүүлэх.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төрийн бодлого, зохицуулалт амьдралд үр дүнгээ өгч байгаад хөндлөнгийн үнэлгээ хийж орон нутгийн малчид, иргэдэд үр дүнг мэдээлж байх.

НЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Бэлтгэл ажил

- 2023 оны 8 дугаар сарын 28-аас 9 дүгээр сарын 2-ны хооронд Африк тивд, Кени Улсын Найроби хотын Накуру хэмээх газарт “Уур Амьсгалын Өөрчлөлтөөс үүдэлтэй хохирол хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГАА”-ны сургалтаар судалгааны бэлтгэл ажил эхэлсэн. Сургалтад Зимбабве, Мексик, Монгол, Нигери, Кени, Колумб улсаас иргэний нийгэм, уугуул иргэд, орон нутгийн иргэдийн байгууллагын төлөөллүүд оролцсон.
- Монгол Улсаас Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбооны (МХБХ) дарга Д.Мөнхзул, Хүний Эрх Хөгжил Төвийн (ХЭХТ) Гүйцэтгэх захирал У.Мандхайцэцэн нар орчуулагч Б.Мөнхжингийн хамт сургалтад оролцсон.
- Дэлхийн дулаарал хурдацтай явагдаж, иргэдийн аж амьдралд уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн хохирол, хор уршгийн талаар ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААГ орон нутагтаа хэрэгжүүлэх судлаачдын багийг сургах, чадавхжуулах, асуудлаа тодорхойлох ур чадвартай болгоход энэ сургалтын зорилго оршсон.
- Энэ сургалтыг гурван сумын Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоо тус бүрээс арван хүний бүрэлдэхүүнтэй багийн нийт 30 оролцогчтойгоор Дарьганга сумд зохион байгуулж, судлаачдын багийг судалгааны арга зүйд сургаж чадавхжуулав.
- Сургалтын өмнө болон дараа судлаачдын багийн дунд цахим уулзалтууд хийж, судалгааны багийн хүмүүст асуудлаа ярилцаж шийдэх боломж бүрдүүлэв. Сургалтын үеэр судалгааг хэрхэн удирдан явуулах, чанартай дүрс, дууны бичлэг яаж хийх, хэлэлцүүлэг ярилцлагыг ямар хэлбэрээр зохион байгуулах талаар ойлголт өгч турших дасгал бүхий бүлгийн ажлуудыг хийв.
- Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбооны гишүүд ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААГ хэрэгжүүлэх багийн зохион байгуулалтаа хэлэлцэж, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, “Хүний эрх хөгжил төв” ТББ-аас боловсруулсан удирдамжийн дагуу судалгааны мэдээлэл цуглуулж, судалгааны үр дүнг хэлэлцүүлж тайлагнав.

Судалгааны зорилго:

1-рт: Орон нутгийн иргэдэд тулгамддаг асуудал, шийдэх арга замыг тодорхойлох.

2-рт: Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хохирол, хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААНЫ багийг чадавхжуулах, орон нутгийн захиргааны хамтын ажиллагааг дэмжих


Судалгааны арга:

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа сум тус бүрд дараах арга, хэрэглэгдэхүүнийг ашигласан. Үүнд:

- Асуулгын арга. Сум бүрд 100 оролцогчтой нийт 300 оролцогчийг хамруулсан 20 асуулт бүхий асуулгаар мэдээлэл цуглуулав.
- Фокус бүлгийн ярилцлага. Фокус бүлгийн ярилцлагыг удирдамжийн дагуу 4 бүлэг оролцогчидтойгоор сум тус бүрд зохион байгуулав. Үүнд: Ахмадын бүлэг, малчдын бүлэг – эрэгтэйчүүд, малчдын бүлэг – эмэгтэйчүүд, зорилтот эмзэг бүлгийн¹ нийт 120 хүн хамрагдав. Фокус бүлгийн ярилцлагын дүнд 4 чиглэл тус бүрээс 2 кейс тохиолдлыг тэмдэглэж, судалгааны мэдээллийг баяжуулав.
- Ганцаарчилсан ярилцлагын кейс: Ганцаарчилсан ярилцлагад гол мэдээлэгчтэй хийх ярилцлагын удирдамжийг ашиглав. Ганцаарчилсан ярилцлагад сум бүрд 10 хүнийг хамруулсан. Засаг дарга, ИТХ-ын дарга, Тамгын газрын дарга, захиргааны мэргэжилтнүүд зэрэг нийт 28 хүн оролцов.

¹ Зорилтот эмзэг бүлэгт олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн эсхүл бэлэвсэн эхнэр, нөхөр бүхий орлого багатай өрхийн хүмүүсийг хамруулав.

Судалгааны хамрах хүрээ:



Судалгаанд сонгож авсан гурван аймгийн гурван сумын малчид, мал бүхий иргэд өрхийн тариалан эрхлэгчид орон нутгийн удирдлагууд

Судалгааны зорилтот газар

- Хэнтий аймгийн Мөрөн сум
- Дорнод аймгийн Баяндун сум
- Сүхбаатар аймгийн Дарьганга сум

ХОЁР: СУДАЛГААНЫ ДҮН

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН СУДАЛГААНЫ ДҮН

Судалгааны багийн гишүүд:

Д.Уранчимэг судалгааны багийн ахлагч, Д.Ариунаа, Н.Занданпүрэв, М.Наранцэцэг, Ц.Нэргүй, Ө.Нямтуяа, Г.Оюун, Ч.Эрдэнэцэцэг.

Судлаачдын үйл ажиллагаа:

Хэнтий аймгийн Мөрөн сумд уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хохирлыг тандан судалж, нөхцөл байдлын талаар мэдээллийг цуглуулах судалгааны ажлыг 2024 оны 4 дүгээр сарын 27–ноос 7 дугаар сарын 3–ны хооронд хийж гүйцэтгэсэн. Судалгааны асуулгад–93; фокус бүлгийн ярилцлагад–39; ганцаарчилсан ярилцлагад– 8, нийт 140 хүнийг хамруулсан. Нийтийн сонсголыг зохион байгуулж, нийт 55 хүнийг урьж оролцуулав.

Хүснэгт 1. Судалгааны асуулгын оролцогчид (Насаар)

Хэрэгсэл	Нас	Оролцогчдын тоо
Асуулга	17–29	6
	30–39	9
	40–49	14
	50–59	33
	60– аас дээш	31
	Нийт	93


Хүснэгт 2. Судалгааны асуулгын оролцогчид (Хүйсээр)

Хэрэгсэл	Хүйс	Оролцогчдын тоо
Асуулга	Эмэгтэй	46
	Эрэгтэй	47
	Нийт	93

Хүснэгт 3. Судалгааны ярилцлагын оролцогчид

Хэрэгсэл	Оролцогчид	Оролцогчдын тоо
ФБЯ	Малчдын бүлэг	10
	Ахмадын бүлэг	10
	Эмэгтэйчүүдийн бүлэг	10
	Зорилтот бүлэг	9
ГЯ	Малчин эрэгтэй	5
	Малчин эмэгтэй	3
	Нийт	47

Хүснэгт 4. Судалгааны асуулгын оролцогчид (боловсролын байдал)



Судалгааны багийн гишүүд

№	Асуулт	Нэгтгэсэн хариулт
1	УАӨ-өөс учирдаг “хохирлыг” юу гэж ойлгодог вэ?	Цаг уурын аюултай үзэгдэл; Олон тооны мал хорогдох; Бэлчээргүй болох; Хөрсний үржил шим алдагдах
2	Танай нутагт УАӨ ямар хэлбэрээр илэрч байна вэ?	Зуд; Ган; Цөлжилт; Шуурга; Хэт халах; Огцом хүйтрэх
3	Танай гэр бүлд УАӨ хэрхэн нөлөөлж байна вэ?	Малын хорогдол –18; ургац алдах–32; эрүүл мэнд; сэтгэл санаа–11, бензин тосны зардал, гамшгийн давтамж, зээлийн төлбөрийн эргэлтийн хөрөнгө багассан.
4	Мал хорогдсон бол хэзээ, ямар шалтгаанаар хэдэн мал хорогдсон бэ?	Нийт хорогдсон малын тоо 2 жилээр: бог – 6302; бод – 1498
5	Ургац алдсан бол хэзээ ямар шалтгаанаар хэчнээн тн/кг ургац алдсан бэ?	• Ургац алдалтын хэмжээ 500–5 тн, том талбайтай газар 10–24 тн.
6	Танай орон байранд ямар хохирол учирсан бэ? Тохирохыг сонгоно уу.	• Байхгүй
7	Хэрэв эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол учирсан бол нэмэлт мэдээлэл өгнө үү.	• Байхгүй
8	Та амьжиргаагаа өмнөх түвшинд хүргэж чадахгүй байх гэж айж байна уу? Яагаад?	Тийм. Яагаад?: Эдийн засаг хэцүү мөнгө бол мөнгө биш болсон. Өмнөх жилүүдийн тоо толгойд малын тоо толгойг хүргэх гэж удах байх.
9	Сүүлд учирсан хохирлыг төгрөгөөр үнэлнэ үү?	Хохирлын хэмжээгээ тооцож үзээгүй, тойм тоогоор үнэлж байгаа нь хэр их эрсдэлд орж байгаагаа сайн тооцоолоогүй нь харагдаж байна.
10	Хохирлоо барагдуулах нөхөн олговор авсан уу?	• Үгүй
11	Хэрэв нөхөн олговор авсан бол яаж?	• Үгүй
12	Хэрэв нөхөн олговор аваагүй бол яагаад?	Хаашаа хандахаа мэдэхгүй.
13	Хохирол учрахад хэнээс дэмжлэг авсан бэ?	Засгийн газар; Орон нутгийн захиргаа; Хамаатан садан; Найз нөхөд.
14	Ямар төрлийн тусламж авсан бэ?	Малын тэжээл; Үр суулгац, бордоо.
15	УАӨ-өөс үүсэх хохирлын эрсдэлийг бууруулахад юу хэрэгтэй вэ?	Төрийн бодлого, зохицуулалт; Хувийн бэлтгэл; Малын ашиг шимийг дээшлүүлэх; Бэлчээрийг зохистой ашиглах; Цаг агаарыг сэрэмжлүүлэх мэдээлэл.
16	УАӨ-ийн асуудлаар МУ-ын бодлого, хууль тогтоомжийн талаар сонссон уу?	• Мэдэхгүй
17	УАӨ-ийн тухай МУ-ын бодлого, зохицуулалтын тухай мэдээлэл авах хэрэгцээ байна уу?	• Тийм
18	УАӨ-ийг бууруулах, дасан зохицох талаар таны ойлголт хэр зэрэг байна вэ?	• Дунд; Муу; Мэдэхгүй
19	УАӨ-д дасан зохицох төрийн бодлого, зохицуулалт амьдралд үр дүнгээ өгч байна уу?	• Мэдэхгүй
20	УАӨ-д дасан зохицоход Та юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?	Бараг тал нь “төрийн бодлого, зохицуулалтын тухай мэдээлэлтэй болох” гэсэн бол 40% орчим нь “Орон нутгийн иргэдийн хамтын санаачилгад нэгдэх”; 5% нь “Нутгийн хүмүүсийн хэрэгцээ, нөөцийн зураглал гаргах” гэж хариулжээ.



Судалгааны багийн гишүүд судалгааны асуулгаар мэдээлэл цуглуулж буй үйл явц

Фокус бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагын явцад тухайн тухайн орон нутагт тохиолдсон байгалийн гамшигт үзэгдэлд өртсөн, эрсдэлийг даван туулсан бодит жишээг давтагдахгүйгээр кейс судалгаанд баримт болгон тэмдэглэж, судалгааны үр дүнг баяжуулсан.

I. Малчдын бүлэг:

- Энэ өвлийн зуданд малынхаа 30%-ийг алдсан. 200–300-аад бог мал бас адуу хорогдсон. Хандив тусламжид 2 уут будаа, 2 кг элсэн чихэр, гурил зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг өгсөн.

(Н.Алтаншагай)

- Өнгөрсөн жил ямаагаа л даатгуулсан. 2023 онд ямаа маш ихээр хорогдсон, 130-аад ямаа хорогдсон. Даатгалаас 1,130,000.00 төгрөг өгсөн. Зуданд бод 30, бог 20-оод, төл голдуу хорогдсон. Хаврын цагт өвс тэжээлийн үнийг тогтвортой байлгах бодлого баривал сайн байна. Өнгөрсөн жил хадлан сайн аваагүй, 4 машин өвс авсан ч хүрэлцсэнгүй. (Н.Алтансүх)
- 2023 онд унага 80-аад, 200-аад хонь уруудуулаад олоогүй, 300 гаруй ямаа хашаандаа үхсэн, 2024 онд 230-аад адуу үхүүлсэн, үхэр бог мал гайгүй. Адуу тэмээ 2-ыг байнга даатгуулах ёстой юм байна лээ. Хонь ямаа дунджаар 150 сая төгрөг, адуу 195,500.000 сая нийт 250 гаруй сая төгрөг болсон.

(3-р багийн малчин Э.Давгадорж)

II. Ахмадын бүлэг:

- Өнгөрсөн жил ногоогоо мөндөрт цохиулсан, нэг га-д ургацаа шавжид идүүлж ургац алдсан, ургацын хэмжээ багассан. Аймаг, сум орон нутгийн удирдлагууд бодлого барьж, мэргэжлийн агрономич ажиллуулмаар байна. Залуу үеийн ногоочид хэрэгтэй байна.

(Н.Болормаа)

- Хэт халалт, ган зэргээс газрын шим бага, ургацын хэмжээ багасаж, хорхой шавж ихтэй болж байна. Цочир хүйтэрч байгаагаас тариалалт хойшилж байна. 6 сарын 1 гэхэд бүх ургац гардаг байсан бол одоо тарьж дуусаагүй л байна. Техник дутагдалтай, хугацаа алддаг.

(Н.Өлзийбямба)

III. Эмэгтэйчүүдийн бүлэг:

- Хавар шөнөдөө хүйтэн, тариалалт оройтож, намар эрт сэрүүсэж байгаа. 1-га-гаас авах ургацын хэмжээ 30–35%-аар багасаж байна. Ургац жижгэрч байна. Ургацыг нэмэгдүүлэхийн тулд хамгаалагдсан хөрсөнд тариалалт хийх, богино хугацаатай ургалттай болцтой сортуудыг сонгох, ялангуяа сонгино, манжин, байцаа, чинжүү гэх мэт ногоонд эрт үрсэлгээ хийх боломжтой. (Ц.Нямсүрэн)
- Өмнөх жилүүдэд 5-р сарын эхээр ногоо тариалаад 6-р сард эхний ургацаа хураадаг байсан. Одоо 6-р сарын 10-наар тариалалт хийдэг боллоо. Цаг хугацаа алдаж, эдийн засгийн алдагдалд орж байна.

(Н.Занданпүрэв)

IV. Зорилтот бүлэг:

- Манай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ногоо тарихад хүн хүч, ажлын бүтээмж, техник дутагдах зэрэг янз бүрийн бэрхшээл учирдаг. Иргэд маань бас жаахан идэвх оролцоо муу байдаг, хурал хийе гэвэл ирдэггүй, нийлж цайлья гэвэл ирдэг. Манай сумд 70 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүн байдаг.

(Н.Ганзориг – Мөрөн сумын ХБХХ дарга)

- 2023 онд эрүүл мэндээр хохирсон, ургац авч чадаагүй. 8х10-ын хүлэмжийн гялгар уут хүчтэй салхинд урагдсан ч боломжоороо нөхөж сэлбээд ургацаа тарьж байна. 2 хүлэмжийн гялгар авахад 1.3 сая төгрөгийн үнэтэй. Төрийн байгууллагад хэлээд дэмжлэг тусламж байдаггүй.

(Б.Болормаа)



Ахмадын бүлгийн ярилцлагын үйл явц



Эмэгтэйчүүдийн бүлгийн ярилцлага



Зорилтот бүлгийн ярилцлагын үйл явц



Ганцаарчилсан ярилцлагын кейс тохиолдол:

Малын тоо толгойн татварыг орон нутгийн иргэдийн саналыг үндэслэн юунд зарцуулах чиглэлээ тодорхойлдог. УАӨ-өөс шалтгаалсан хохирлын үнэлгээ, малын тоо толгойн хорогдолд нарийвчилсан үнэлгээ гараагүй. Мөнгөн дүнг тооцож үзээгүй. УАӨ-өөс бэлчээрийн даац хэтэрсэн, хадлан тэжээл бэлтгэх хэмжээнд ургац ургахаа больсон. (Б.Мягмаржав – Засаг даргын орлогч)

Малгүй болж хохирол амссан өрхүүдийг малжуулах хөтөлбөр зарлагдсан. Өмнө нь 5 сая байсан, энэ жил 8 сая болж өссөн байна. Хүүгүй барьцаагүй 3 жилийн хугацаатай зээл олгож байна. Энэ нь малчдад дэмжлэг болж байна. (Д.Золзаяа – 5-р багийн засаг дарга)

Манай байгууллагын хувьд 2 машинтай, нэг нь пургон машин, актлаад 2 жил болж байна. Өвлийн бүрхүүл ихтэй зудын үед хөдөө дуудлагад явахад хүндрэлтэй байдаг. Малчдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, зуны улиралд малчдад зохих эмчилгээ хийж, хяналтдаа авч ажиллаж байгаа. (Б.Гандолгор–ЭМТ-ийн дарга)

Өвс тэжээлийн фонд байгуулахад малын хөлийн татвараас жилдээ 60.0 сая төгрөг төвлөрдөг. Хууль дүрмийнхээ дагуу багуудад жилдээ нэг бэлчээрийн гүний худаг гаргах төлөвлөгөөтэй байдаг. Өвс тэжээлийн зардалд 20.0 сая төгрөг зарцуулдаг. Нэг боодол өвсийг 10,000 төгрөгөөр бодож 2000 боодол өвс л худалдан авдаг. 5 багийн 500 гаруй малчдад хаана нь ч хүрдэггүй. Байгалийн гамшгийн үед боодол өвсийг хямдруулаад яг л авсан үнээрээ өгдөг. (Б.Мягмаржав – Засаг даргын орлогч)



Н.Норов – Хэнтий аймгийн Мөрөн сумын
Тамгын Газрын дарга



Хаврын салхинд унасан хүлэмж 20х6 хэмжээтэй
2 хүлэмжээ алдсан

НИЙТИЙН СОНСГОЛ

2024 оны 7 сарын 3–нд Хэнтий аймгийн Мөрөн сумд Нийтийн сонсголын хэлэлцүүлэгт олон талт төлөөлөл болох нийт 56 хүн оролцсон.

Нийтийн сонсголыг нээж ХЭХТ–ийн тэргүүн Г.Уранцоож үг хэлэв. Тэрбээр хэлэхдээ: Та бүхэнд судалгааны дүнг хэлэлцүүлэх гэж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн хор хохирлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга туршлагыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, аль болох хор хохирол багатайгаар амьдрал ахуйгаа удирдаж явах талаар иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой. Иймд та бүхний явуулж буй энэхүү үйл ажиллагаа нь энэ зорилгод тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах байх гэж найдаж байна. Энэ хэлэлцүүлгээр иргэд тодорхой мэдлэг мэдээлэлтэй өөрсдийн гэсэн дүн, баримттай болох юм. Уг мэдээллийг ашиглаад сум, аймаг, үндэсний түвшинд уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан хохирол, хор уршгийн талаар ярих юмтай болно. Түүнчлэн олон нийтээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үндэсний хэмжээний бодлогод нөлөөлөх боломжийг бий болгоно. Энэ хэлэлцүүлэгт амжилт хүсье.

Ч.Эрдэнэцэг – Мөнгөн хуримтлалын Бүлгийн ахлагч, Улсын аварга тариаланч

Миний хувьд Хүний Эрх Хөгжил Төвтэй 3 дахь удаагаа үр өгөөжтэй хамтран ажиллаж байна гэж бодож байна. Өмнө нь бидэнд олон төрлийн чиглэлээр тусламж дэмжлэг үзүүлж байсан. Манай бүлгийн гишүүд ч гэсэн ажлаа сайн гүйцэтгэдэг. Бүлгийн гишүүддээ баярлаж явдгаа хэлье. 2004 оноос хойш бид хамтдаа сайхан ажиллаж хөгжиж байгаа хүмүүс юм.

Би өөрөө тариаланч мэргэжилтэй. Мөрөн сумын ногоо тарьдаг хүмүүст мэргэжлийн зөвлөгөө маш сайн өгье гэж бодож явдаг. Одоо юм бүхэн хөгжиж байна. Улсаас дэмжээд техник тоног төхөөрөмж өгөөд байхад уламжлалт аргаараа ногоо тарьсаар л байна. Яагаад бие эрхтэн, нуруу нугасаа хайрладаггүй юм. Өмнөөс нь хөл гар өвдөөд янгинаад явчихдаг. Шуудуу татаад усалгаа хийхийг нь хараад өмнөөс нь сэтгэл өвдөөд байдаг. Ахмадуудын араас залуу халаа ногоочин болох хүсэлтэй хүүхдүүд та бүхний энэ уламжлалт аргыг хараад бэрхшээдэг болно шүү.

Тэрбээр цааш хэлэхдээ: Ахмадуудын тарьж байсан сайхан цагаан хальстай сармисыг одоо тарихаа больжээ. Нутгийн брэнд гэдгийг ногоочид бараг мартчихаад байгаа. ХХААЯ–наас өгч байгаа сармисны үр, үрсэлгээгээр ногоо тарьдаг болжээ. Цаашдаа голын ус багасна. Учир нь цаг агаарын дулаарал, уур амьсгалын өөрчлөлт их явагдана. Уламжлалт аргаар ногоо тарих нь зохимжгүй болж байна. Тиймээс усалгааны бороожуулах, нарийхан намираа татах гэх мэт аргыг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх нь зүйтэй болов уу.

Н.Алимантуяа – Мөрөн сумын ногоочин, ахмад настан

Сүүлийн жилүүдэд цаг агаарын төлөв байдлаас болж өвс тэжээл, хадлан бордоогоо гүйцэд хэмжээнд авч чадахгүй болж байна. Дэлхийн дулаарлаас үүдэлтэйгээр цаг агаар ихээхэн өөрчлөгдөж, хүмүүст захирагдахгүй болж байна. Үүний нэг тод жишээ бол манай нутагт бэлчээрийн даац хэтэрсэн. Ургадаг ургамал нь ургахаа больсон,

гарц нь багассан, олон төрлийн ургамал ургаж чадахаа байлаа. Малын хашаа саравчгүйгээс болж малчид малаа уруудуулах, цасан шуурганаар алдах зэрэг эрсдэлд ордог. Тиймээс болзошгүй аюулаас урьдчилан сэргийлж малын саравч хашаа хороотой болох, сайжруулах хэрэгтэй юм. Миний хувьд малчдын хоршоог дэмжиж байгаа.

Н.Даваажав – Мөрөн сумын ногоочин

Малынхаа түүхий эдийг бүтээгдэхүүн болгох боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Малчид аргамжаа, хазаараа өөрсдөө хийдэг байсан, одоо эрс багассан. Малын арьсаа зүгээр хаячихдаг болсон. Түүхий эдээ бүтээгдэхүүн болгох арга замаа мэдэхгүй байна. Өөхөө ашиглаад саван хийдэг болоод байгаа. Ахмадууд л малаа арчилж торддог болчихоод байна. Залуучууд ихэнх нь сурна гээд гадагш явчихдаг. Залуучуудад малын үр шимийг ашиглах, гэр үйлдвэр эрхлэх арга замыг зааж сургах хэрэгтэй.



*Б.Мягмаржав – Засаг даргын орлогч.
Нийтийн сонсголын үеэр*



*Д.Уранчимэг – МХБХ-ны дарга, судалгааны
багийн ахлагч*



Нийтийн сонсгол, Хэнтий аймгийн Мөрөн сум 2024 оны 07 дугаар сарын 03



Нийтийн сонсголын үйл явц

Дүгнэлт

Энэ судалгааг хийснээр бүлгийн гишүүд өөрсдөө судалгаа хийж болдогийг мэдэж авлаа. Мал сүрэг үхэх нь үхэж, ургац алдах нь алдаж л байдаг гэсэн амьдралын хэвшмэл ойлголттой байгаа нь ажиглагдлаа. Малчид, өрхийн тариалан эрхлэгчид хохирлоо тооцож үздэггүйгээс санхүүгийн дэмжлэг авах талаар хөөцөлддөггүй, хөөцөлдсөн ч хайхрах газар, байгууллага байдаггүй. Эдийн засгийн алдагдлаа нөхөх талаар төлөвлөдөггүй хандлага их байна. Энэ талаар чиглэсэн мэдээлэл байхгүй, бодлого байхгүй, байсан ч үр шимийг нь хүртэж мэдэхгүй. Малын Индексжүүлсэн Даатгалын систем сайн биш, дөнгөж эхлэл төдий байна.

УАӨ-өөс үүдэлтэй хор хохирлын хэмжээг тооцож байх хэрэгтэй. Малчид амьжиргааны эх үүсвэр болсон малаа зуднаар алдсан тул өөрсдийн хүчин чадалд тохирсон мал маллах, хүнсний ногоо тариалах, усалгааг механикжуулах, гар ажиллагааг аль болох халах зэрэг асуудлыг шийдэх нь чухал болж байна. Шинэ асуудлыг дэвшүүлж нийгэмд мэдүүлэх, цаашид төр засгийн бодлогод нөлөөлөх, даатгалын системийг боловсронгуй болгоход анхаарах, өрхийн тариалан эрхлэгчдэд ургацын даатгалтай болох боломжийг судлах, малчдад даатгалын талаар ойлголт өгөх зэрэг ажлуудыг хийж болохоор байна.

Судалгааны дүнг нэгтгэж олон улсын байгууллагад тайлагнахаас гадна, төр засагтаа албан ёсоор бичгээр болон амаар танилцуулж, төрийн бодлого зохицуулалтад зохих шийдвэрийг тусгуулж ажиллавал зүйтэй санагдлаа.

Зөвлөмж

Зөвлөмжийг Хэнтий аймгийн Мөрөн сумын Судалгааны багийн хамт олноор ахлуулсан судалгааны үр дүнд үндэслэн боловсруулав.

I. Орон нутгийн засаг захиргаанд:

- УАӨ-өөс үүдсэн хохирлын хэмжээг тооцдог дадалд иргэдийг сургах, байгаль цаг уурын эрсдэлээс хамгаалах төлөвлөгөөтэй ажиллах
- Хохирол, хор уршгийг бууруулахад малчид ногоочдод дэмжлэг үзүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хохирлыг бууруулах мэдлэг, ур чадварт малчдыг сургах, төлөвшүүлэх

II. Малчдад:

- Малчид өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангах, өвс тэжээлийг өөрсдийн малын тоо толгойд тохирсон хэмжээгээр бэлтгэж байх.
- Өвөлжөө хаваржааны хашааны бүтүүмжлэлийг сайжруулах.
- Малын тоо толгойг өөрсдийн хүчин чадалд тохируулан өсгөх, өндөр ашиг шим өгдөг чанартай мал маллах.
- Өвөлжөө хаваржааны бэлчээрийг зуны цагт чөлөөлж, бэлчээрээ сэргээж байх.
- УАӨ-өөс учирсан хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тооцож сурах, зохих газарт нь уламжилж баримтжуулж байх.
- Малаа даатгалд бүрэн хамруулах.

III. Өрхийн тариалан эрхлэгчид:

- УАӨ-өөс үүдэн хаврын тариалалт оройтож байгаа учраас хамгаалагдсан хөрсөнд тариалалт хийх, эрт үрсэлгээ хийх.
- Байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан хохирлыг мөнгөн дүнд шилжүүлэн зөв тооцож сурах.
- Мэргэжлийн хүний зөвлөгөө авч, технологийн дагуу хортон шавжтай тэмцэх.
- Хаврын тариалалт, усалгааны үед техник ашиглан хүчин чадлыг нэмэгдүүлэх, аль болох гар ажиллагааг хөнгөвчлөх арга замыг хайх.
- Зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа ногоог түлхүү тариалж, эдийн засгийн ашиг орлогоо нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

IV. ТББ-д:

- Малын Индексжүүлсэн Даатгалын системийг боловсронгуй болгох, хохирлын нөхөн төлбөрийг олгох шинэ боломж хувилбаруудыг сонгон судлах.
- УАӨ-өөс шалтгаалсан хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах мэдлэг чадварт малчдыг сургах.
- Судалгааны дүнг нэгтгэж олон улсын байгууллагад тайлагнахаас гадна төр засагт албан бичгээр болон амаар танилцуулж, төрийн бодлого зохицуулалтад зохих шийдвэрийг тусгуулж ажиллах.
- Өрхийн тариалан эрхлэгчийн ургацын даатгалын системийг оновчтой байдлаар шийдэх асуудал боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

Судалгааны багийн гишүүд:

Судалгааны баг 9 гишүүнтэй, багийн ахлагчийг оролцуулаад зургаа нь эмэгтэй, гурав нь эрэгтэй байв. Тэд бүгд Баяндун сумын МХБХ-ны гишүүд болно. Я.Мөнхзул судалгааны багийн ахлагч, багийн гишүүд П.Амгаланбаатар, Б.Байгалмаа, Б.Бат-Эрдэнэ, Л.Доржмаа, Л.Дуламханд, Н.Жаргалцэцэг, Л.Түмэннаст, Б.Хишигтэй хамт судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлан бичих, хэлэлцүүлэх ажлыг гүйцэтгэсэн.


Судлаачдын үйл ажиллагаа, судалгаанд оролцогчдын мэдээлэл:

Дорнод аймгийн Баяндун сумын Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбооны судлаачдын багийн 9 гишүүд хамтран уур амьсгалын өөрчлөлтийн хохирол, хор уршгийн тухай ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААГ 2024 оны 4 дүгээр сарын 27–ноос 7 дугаар сарын 3–ны хооронд хийж гүйцэтгэв.




Судалгааны багийн гүшүүд


Хүснэгт 1. Судалгааны ярилцлагын оролцогчид (насаар)



Хүснэгт 2. Судалгааны асуулгын оролцогчид (боловсролын байдлаар)



Хүснэгт 3. Судалгааны асуулгын оролцогчид (ам бүлийн тоогоор)



ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН СУДАЛГААНЫ ДҮН

№	Асуулт	Хариулт нэгтгэсэн байдлаар
1	УАӨ-өөс учирдаг “хохирлыг” юу гэж ойлгодог вэ?	Цаг уурын аюултай үзэгдэлд олон тооны мал хорогдох; бэлчээргүй болох; хөрсний үржил шим алдагдах; хүмүүсийн амь нас эрсдэх.
2	Танай нутагт УАӨ ямар хэлбэрээр илэрч байна вэ?	Зуд шуурга; цочир хүйтрэл; гал түймэр; цөлжилт
3	Танай гэр бүлд УАӨ хэрхэн нөлөөж байна вэ?	Малын хорогдол; эрүүл мэнд; сэтгэл санаа
4	Мал хорогдсон бол хэзээ, ямар шалтгаанаар хэдэн мал хорогдсон бэ?	Судалгаанд оролцогсод 2022–2024 онд 4968 бог мал, 1354 бог малаа хүйтэн бороо, шуурга, зудаар алдсан.
5	Ургац алдсан бол хэзээ ямар шалтгаанаар хэчнээн тн/кг ургац алдсан бэ?	Байхгүй
6	Танай орон байранд ямар хохирол учирсан бэ? Тохирохыг сонгоно уу.	Малын хашаа саравч
7	Хэрэв эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол учирсан бол нэмэлт мэдээлэл өгнө үү.	Эрүүл мэнд, сэтгэл санаа хямаар, нүүрээ хөлдөөх, гараа хайруулах, даарч хөрөх, даралт ихсэх, сахар нэмэгдэх, зүрх өвдөх, нуруу өвдөх, малчны зээлийн төлөлт ойртоод сэтгэл санаа хямаар.
8	Та амьжиргаагаа өмнөх түвшинд хүргэж чадахгүй байх гэж айж байна уу? Яагаад?	Тийм. Эх малын хорогдол малын өсөлтөд нөлөөлж байна. Цөөн малтай айл зудад нэрвэгдэж малгүй болох
9	Сүүлд учирсан хохирлыг төгрөгөөр үнэлнэ үү.	Судалгаанд оролцогчдын 30 хүртэлх хувь нь 5–15 сая төгрөг; 10 хувь нь 20–30 сая төгрөг; 11 хувь нь 30 сая төгрөгөөс дээш гэж үнэлэв.
10	Хохирлоо барагдуулах нөхөн олговор авсан уу?	Аваагүй.
11	Хэрэв нөхөн олговор авсан бол яаж?	Хариулт байхгүй.
12	Хэрэв нөхөн олговор аваагүй бол яагаад?	“Хаана хэнд хандахаа мэдэхгүй” гэж 88 хувь.
13	Хохирол учрахад хэнээс дэмжлэг авсан бэ?	60 хувь нь тусламж дэмжлэг огт аваагүй; 27 хувь нь орон нутгийн захиргаа, нутгийн зөвлөлөөс; 13 хувь нь Дэлхийн зөн олон улсын байгууллага, улаан загалмайгаас
14	Ямар төрлийн тусламж авсан бэ?	Малчин өрхүүдэд 1 шуудай тэжээл хөнгөлөлттэй үнээр; Орон нутгийн засаг захиргаа, нутгийн зөвлөлөөс малчдын 38 хувьд эмийн сан; “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагаас хүнсний бүтээгдэхүүн олгосон байна.
15	УАӨ-өөс үүсэх хохирлын эрсдэлийг бууруулахад юу хэрэгтэй вэ?	Хувийн бэлтгэлтэй байх; өвс тэжээл, бэлчээрийг зохистой ашиглах; төрийн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх; малын ашиг шим үүлдэр угсааг сайжруулах; цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээллийн дагуу бэлтгэлээ хангах.
16	УАӨ-ийн асуудлаар МУ-ын бодлого, хууль тогтоомжийн талаар сонссон уу?	Судалгаанд оролцогчид бүгд “үгүй” гэж хариулсан.
17	УАӨ-ийн тухай МУ-ын бодлого, зохицуулалтын тухай мэдээлэл авах хэрэгцээ байна уу?	Бүгд хэрэгцээ байна гэж хариулсан.
18	УАӨ-ийг бууруулах, дасан зохицох талаар Таны ойлголт хэр зэрэг байна вэ?	Дунд зэрэг
19	УАӨ-д дасан зохицох төрийн бодлого, зохицуулалт амьдралд үр дүнгээ өгч байна уу?	Мэдэхгүй
20	УАӨ-д дасан зохицоход Та юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?	Төрийн бодлого, зохицуулалтын талаар мэдлэг, мэдээлэл авах; орон нутгийн захиргаа, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах; ургацын даатгалд хамрагдах; малчны нийгмийн даатгалыг сайжруулах.

I. Малчдын бүлэг:

- Орлого муу, түүхий эдийн үнэ уналттай, амьжиргаа хүнд байна. Тиймээс малчдыг (эмэгтэй малчид) төрөөс бодлогоор дэмжих, эрүүл мэндийг хамгаалах.
- Булаг шанд болон усны ундаргатай газар геологийн хайгуул болон олборлолт хийлгэхгүй байх.

II. Ахмадын бүлэг:

- Энэ бүлэг залуусын тухай “Залуу үе их залхуу болсон байна. Үнээ малаа ч саахгүй, малын ашиг шимийг бүрэн ашиглахгүй, нэмэгдүүлэхэд анхаарахгүй байна” гэсэн нийтлэг санаа илэрхийлсэн. Мөн “хүүхэд, залуучуудад уур амьсгалын өөрчлөлтийн талаар ойлголт өгөх нь чухал” гэдгийг онцгойлсон.
- Нэг газраа бөөнөөрөө зусах, өвөлжих нь бэлчээрийн талхагдал, цөлжилт үүсэх аюултай. Малын хорогдлын мэдээг үнэн зөв бодитой гаргах хэрэгтэй.

III. Эмэгтэйчүүдийн бүлэг:

- Өрхийн тариалан эрхлэгч эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник их шаардагдаж байна. Хүнсний ногооны тариалалт, гарц улам бүр дордож байна. Хорхой шавжны устгал хийх, усалгааны асуудлаа шийдээгүй ирсэн.
- Гамшгийн хүнд хэцүү үед нь малчид, өрхийн хүнсний ногоо тариалагчдад эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх, гамшгаас учирсан хохирол, хор уршигт нөхөн төлбөр олгох даатгалтай болох, малын индексжүүлсэн даатгалтай болох зэрэг ажил хэрэгтэй байна.

IV. Зорилтот эмзэг бүлэг:

- Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх, орлогоо нэмэгдүүлэх, малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд дэмжлэг хэрэгтэй.
- Цаг агаарын мэдээллийг тогтмол авах, багийн засаг дарга малчдын хотыг байнга эргэж тойрч дэмжлэг тусалцаа үзүүлэх.



Ахмадын бүлэгтэй хийсэн
ярилцлагын үйл явц



Эмэгтэйчүүдийн бүлэгтэй хийсэн ярилцлагын үйл явц



Ганцаарчилсан ярилцлагын гол үр дүн, кейс тохиолдол:

- Малчид хоорондоо хөдөлмөрөө хоршиж, өвлийн бэлтгэлээ хамтран хийвэл байгалийн гамшигт аюулаас учрах эрсдэлийг хохиролгүй давах боломжтой юм.
- Отрын газарт бизнесийн хадланг авахыг болиулах хэрэгтэй. Малынхаа сэг зэмийг устгах асуудал малчдад хүндхэн байсан.



Судалгааны явцаас

НИЙТИЙН СОНСГОЛ

Нийтийн сонсгол Баяндун сумын Соёлын төвд 2024 оны 7 сарын 05–ны өдөр зохион байгуулагдсан. Орон нутгийн төлөөлөл, иргэд, малчид, орон нутгийн захиргаа, байгаль орчны төлөөлөл оролцсон. Нийт 40 оролцогчид хамрагдсан болно.

Нийтийн сонсголыг нээж Хүний эрх хөгжил төвийн Тэргүүн Г.Уранцоож үг хэлэв. Тэрбээр хэлэхдээ:

Энэ удаад нийтийн сонсголыг зохион байгуулж, судалгааны дүнг олон хүмүүст танилцуулахаар тус сумын судалгааны баг ажиллаж байна. Судалгааны дүнг олон нийтэд хүргэхэд иргэдийн санаачилгаас гадна орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын ажилтнуудын ойлголт, хамтын ажиллагаа чухал юм.

Зөвхөн нэг удаагийн судалгаа, дүгнэлт, хэлэлцүүлэг хийснээр судлаачдын багийн ажил дуусгавар болохгүй. Учир нь, уур амьсгалын өөрчлөлт цаашид ч үргэлжилж, давтамж нь эрчимжих төлөвтэй байна. Иймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох дадал чадварыг дээшлүүлэх, эрсдэлийг давж гарах, бууруулахад нэг талаас иргэдийн хувийн бэлтгэл, нөгөө талаас зохион байгуулалт, хамтын ажиллагаа нэн шаардлагатай болж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь хувь хүний хүчин чадлаас давсан хохирол, хор уршгийг дагуулдаг болохыг харууллаа. Тиймээс хүмүүст асуудлаа ярилцах, хэлэлцэх боломжийг гаргаж өгье гэсэн зорилгоор энэ хэлэлцүүлгийг хийж байгаа билээ.

Дорнод аймгийн Баяндун сумын МХБХ–ны Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Хишигт хэлсэн үгэндээ:

Төрөөс малчдын талаар баримтлах бодлого тун хэрэгтэй. Түүхий эдийн үнэ уналттай, орлого муу энэ үед малчдаа эрүүл мэнд, гэр бүлийг дэмжих шаардлага гарч байна. Малын ашиг шим үнэ хүрэхгүй, борлуулалтгүйгээс заримыг нь хаяж малчдын амьжиргаа хүндэрч байна. Энэ асуудлаар төрд дуу хоолойгоо хүргэх гэж энэ судалгааны дүнгээр нийтийн сонсгол хийж орон нутгийн удирдлагуудад хүргэж байгааг тэмдэглэсэн.

Хүүхдэд багаас нь уур амьсгалын өөрчлөлт гэж юу болох, эрсдэлийг даван туулахад ямар боломж гарц байх, өөрөөсөө хамаарсан юу хийж чадахыг ойлгуулах нь зүйтэй. Малчдыг сургаж чадавхжуулах шаардлагатай.

Өнгөрсөн хавар шуургатай, цагаан зудтай байлаа. Малын хорогдол их гарсан, төр засгаас малын сэг зэмийг устгах төрийн кампанит ажлыг хангалттай сайн хийгээгүй. Малчид өөрсдөө туйлдсан байхад малынхаа сэг зэмийг устгах асуудал тэдэнд хүндхэн тусаж байсан. Төрийн түшээд, хариуцсан бодлогын байгууллагууд энэ асуудалд анхаарах нь зүйтэй. Малаа малласаар байгаа малчдад гамшгийн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгтэй. Малын хорогдлыг бодитой үнэлдэг баймаар байна.

Залуу үе их залхуу байна. Малын ашиг шимийг нэмэгдүүлэхэд анхаарахгүй байна. Өндөр настан малаа малласаар л байгаа, яаралтай тусламжийг хүргэхгүй байна. Малын хорогдлыг бодитой тооцож гаргахад багийн засаг дарга, мэргэжилтнүүд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Сумын хэмжээнд хог хаягдлын менежментэд анхаарахгүй байна. Хогоо дураараа хаядгаас үүсэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил хийх шаардлагатай.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд малчид, мал бүхий иргэд, өрхийн тариалан эрхлэгчид ихээр өртсөн бөгөөд хохирлоо барагдуулах нөхөн төлбөр авдаггүй, хаана хэнд хандахаа мэддэггүй, мэдээллээр дутмаг байна. Зөвхөн өнгөрсөн жилийн өвөл, хаврын (2023 он) хугацаанд малын хорогдол сумын хэмжээнд 4063 толгой малд хүрч үүнээс адуу 153, үхэр 713, хонь 1781, ямаа 1380 нийт малын 1.58%-ийн үзүүлэлттэй байна. Малын индексжүүлсэн даатгалаар сумын нийт малын 6 хувь хорогдсон тохиолдолд малчдад нөхөн олговор олгодог. Энэ хувь өндөр учраас малчдад хүртээмжгүй, олноор малаа алдсан ч нөхөн олговор авахгүйд хүрч байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээг тогтмол хүлээн авч, өвс хадлан тэжээл, хашаа хороогоо бэлдэж, малаа вакцинжуулж, тордож тэжээн, хувийн бэлтгэлээ сайн хангасан ч байгалийн олон давтамжтай аюулт үзэгдлийн өмнө малчид хүчин мөхөсдөж байна.

Залгамж халаа залуу малчдыг дэмжиж, мал аж ахуй эрхлэх, дэмжих ажлын байрыг бий болгох бодлого, зохицуулалт дутагдсаар байна. Өрхийн хүнсний ногоо тариалагчдын үйл ажиллагааг техникжүүлэх тоног төхөөрөмжөөр ханган гар ажиллагааг багасган хөдөлмөрийг нь хөнгөвчлөх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг даван тэсвэрлэх, дасан зохицох чадавхыг үе шаттай бэхжүүлэх төрийн бодлого зохицуулалтыг бий болгох ажил орон нутаг, үндэсний түвшинд оролцоог хангахгүй байна.



Судалгааны мэдээлэл боловсруулах ажлын үеэр

Зөвлөмж

Баяндун сумд хийсэн иргэдийн судалгааны дүн малчдаа дэмжсэн гамшгийн эрсдэлийг бууруулах төрийн бодлого, зохицуулалт бүхий хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх нь чухал болохыг тодорхой харууллаа. Уур амьсгалын өөрчлөлтөөс малчдад учирсан хохиролд нөхөн олговор олгох, малжуулах, үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Эс бөгөөс эрчимжсэн мал аж ахуй руу шилжих, бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга барилыг орхиход нэмэр болох нэг хүчин зүйл болж байна.

Судалгааны дүнд үндэслэн дараах 4 суурь асуудлын хүрээнд дэвшүүллээ. Үүнд:

1. УАӨ-д дасан зохицох: Орон нутгийн захиргаанаас иргэдийг дайчлан өөрөөсөө хамаарах бүхий л бололцоог дайчлан гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
2. Бэлчээр хамгаалах: Аймгийн Засаг Даргын захирамжаар нутаг дэвсгэрийн хэмжээнд гадны мал оруулахыг хориглосон. Энэ шийдвэрийг хэрэгжүүлэх.
3. Ундны болон бэлчээрийн усан хамгамжийг сайжруулах: Ундны усны хүртээмжийг сайжруулах, бэлчээрийг усжуулах арга хэмжээ авч, ус дагаж нэг газар бөөнөөр нүүдэллэхийг зогсоох.
4. Малын болон хүнсний ногооны даатгал: Сумын малын нийт хорогдол 6 хувиас дээш байх даатгалын босгыг багасган даатгал хийлгэсэн малчин бүр хорогдлын хэмжээгээр нөхөн төлбөр авдаг болох. Хүнсний ногоо тариалагчдад хохирол барагдуулах даатгалтай болох.

I. Орон нутгийн засаг захиргаанд:

- Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах тухайн жилийн орон нутгийн төсвийн нэг хувийг нэмэгдүүлэх, хуулийн этгээдийн үйлдвэр, үйлчилгээний зардлын 165 хувьтай тэнцэх хөрөнгийн зарцуулалтын дүнг ил тод болгох.
- Зудын үед цасны зузааныг хэмжих 4 тогтсон цэгийн байршлыг өөрчлөн зудын хэмжээг бодитой тогтоодог болох.
- Цас, цасан шуурганаас хамгаалах бургас тарих.
- Малын индексжүүлсэн даатгалын системийг боловсронгуй болгож, малчин бүрд хүртээмжтэй болгох.
- Ногоочдын бизнесийг гамшгаас хамгаалах даатгалыг нэвтрүүлэх.
- УАӨ-өөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үнэлэн орон нутгийн иргэдэд нээлттэй тайлагнадаг болох.
- Гамшгаас сэргийлэх, эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг хөгжүүлэх.
- ЗДТГ болон Шуурхай штабыг онцгой байдлын үед ажиллах туулах чадвар сайтай техник хэрэгслээр хангах.
- Малчдын эрүүл мэндийг хамгаалах, хүнд үед сэтгэл санааг дэмжих ажил хийдэг болох.
- Хог хаягдлын менежменттэй болох.
- Мал бүхий иргэдийг аливаа тусламж дэмжлэгт хамруулах.

II. Малчдад:

- Малчид малын индексжүүлсэн даатгалд бүрэн хамрагдах.
- УАӨ нь сүүлийн жилүүдэд давтамж нь ихсэж байгаа тул хувийн бэлтгэл, өвс тэжээлээ өөрийн малын тоо толгойд тохируулан бэлтгэх.
- Бэлчээрийн сэлгээг жил бүр улирлын дагуу /өвөлжөө хаваржаа зуслан/ хийж өвөлжөө, хаваржааны хашаа саравчны битүүмжийг сайжруулах.
- Малын үүлдэр угсааг сайжруулж, тоо толгойг өөрийн хүчин чадалд тохируулж маллах.
- УАӨ-өөс хохирсон хохирлын хэмжээг мөнгөн дүнгээр тооцож баримтжуулан албан ёсны газарт мэдээлж, бүртгүүлж байх.

III. Өрхийн тариалан эрхлэгчдэд:

- УАӨ-өөс болж хаврын тариалалт оройтож байгаа учраас хөрсөө хамгаалах, үрсэлгээ хийж тариалах.
- УАӨ-өөс учирсан хохирлоо зах зээлийн үнээр зөв тооцон, мөнгөн дүнд шилжүүлдэг болох.
- Мэргэжлийн хүний зөвлөгөөний дагуу хортон шавж, зэрлэг ургамалтай тэмцэх.
- Бүтээмжээ нэмэгдүүлэх: Шинэ техник, технологи нэвтрүүлж, хөдөлмөрөө хорших.
- Хүлэмжийн аж ахуй эрхлэх, агропарктай болох.



Ц.Гантуяа
Баяндун сумын Тамгын
Газрын дарга



Я.Мөнхзул
судалгааны багийн ахлагч
МХБХ-ын дарга



Д.Хишигт судалгааны
багийн гишүүн



Нийтийн сонсголын үеэр



Нийтийн сонсгол, Дорнод аймгийн Баяндун сум 2024 оны 07 дугаар сарын 05

СУХБААТАР АЙМГИЙН ДАРЬАНГА СУМЫН СУДАЛГААНЫ ДҮН

Судалгааны багийн гишүүд:

Д.Мөнхзул судалгааны багийн ахлагч, Д.Ариунцэцэг, Ц.Батхүрэл, М.Борчулуун, Л.Борхүүхэн, Ж.Бямбаа, Д.Дариймаа, Д.Дугарсүрэн, Ж.Мөнхцэцэг, Н.Урьдынбиш.

Судлаачдын үйл ажиллагаа:

Судалгааг 2024 оны 05 дугаар сарын 27–ноос 2024 оны 07 дугаар сарын 04–ний өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Нийт 150 хүн тус судалгаанд хамрагдав.


Хүснэгт 4. Судалгааны асуулгын оролцогчид
(Насаар)

Хэрэгсэл	Нас	Оролцогчдын тоо
Асуулга	23–30	10
	31–35	12
	36–40	15
	41–45	14
	46–50	17
	51–55	10
	56–60	7
	61–65	10
	66–70	4
	70–аас дээш	1
Нийт		100

Хүснэгт 5. Судалгааны асуулгын оролцогчид
(Мал аж ахуй бизнесээр)

Хэрэгсэл	Мал аж ахуйн бизнес	Оролцогчдын тоо
Асуулга	Малчин	85
	Мал бүхий иргэн	15
	Нийт	100

Хүснэгт 6. Судалгааны асуулгын оролцогчид
(хүйсээр)



Хүснэгт 7. Судалгааны асуулгын оролцогчид
(хүйсээр)

Хэрэгсэл	Оролцогч	Оролцогчдын тоо
ФБЯ	Малчин эрэгтэйчүүд	10
	Малчин эмэгтэйчүүд	10
	Ахмадууд	10
	Зорилтот бүлгийн хүмүүс	10
ГЯ	Эмэгтэй	5
	Эрэгтэй	5
Нийт		50



Судалгааны багийн гишүүд

СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ДҮН

№	Асуулт	Нэгтгэсэн хариулт
1	УАӨ-өөс учирдаг “хохирлыг” юу гэж ойлгодог вэ?	Нийтлэг хариулт: Бэлчээргүй болох; Хүн хүч дутагдах; Ургац алдах.
2	Танай нутагт УАӨ ямар хэлбэрээр илэрч байна вэ?	Зуд; Гал түймэр; Цочир хүйтрэл.
3	Танай гэр бүлд УАӨ хэрхэн нөлөөлж байна вэ?	Малын хорогдол; Эрүүл мэнд; Сэтгэл санаа; Ургац алдах.
4	Мал хорогдсон бол хэзээ, ямар шалтгаанаар хэдэн мал хорогдсон бэ?	Судалгааны асуулгад оролцогчдоос 77 хүн 2024 оны зудаар нийт 14428 бод, бог мал алдсан байна.
5	Ургац алдсан бол хэзээ ямар шалтгаанаар хэчнээн тн/кг ургац алдсан бэ?	Нийт алдсан ургац 3 жилээр: 160 –700 кг
6	Танай орон байранд ямар хохирол учирсан бэ? Тохирохыг сонгоно уу.	Гэр, байшин, малын хашаа, саравч хүчтэй салхинаас эвдэрсэн
7	Хэрэв эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол учирсан бол нэмэлт мэдээлэл өгнө үү.	Эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирох, нүүрээ хөлдөөх, гараа хайруулах, даарч хөрөх.
8	Та амьжиргаагаа өмнөх түвшинд хүргэж чадахгүй байх гэж айж байна уу? Яагаад?	Тийм. Яагаад гэвэл байгалийн уур амьсгалын өөрчлөлтөөс малчдад ихээхэн эрсдэл үүсэж байна.
9	Сүүлд учирсан хохирлыг төгрөгөөр үнэлнэ үү.	Хүн бүр дунджаар 5 сая төгрөгийн хохирол амссан.
10	Хохирлоо барагдуулах нөхөн олговор авсан уу?	Нэг ч хүн аваагүй.
11	Хэрэв нөхөн олговор авсан бол яаж?	
12	Хэрэв нөхөн олговор аваагүй бол яагаад?	“Хаашаа хандахаа мэдэхгүй” гэж бүгд хариулсан.
13	Хохирол учрахад хэнээс дэмжлэг авсан бэ?	Орон нутгийн захиргаа; Хамаатан садан; Найз нөхөд.
14	Ямар төрлийн тусламж авсан бэ?	Малын тэжээл; Хүлэмж; Эм, тариа.
15	УАӨ-өөс үүсэх хохирлын эрсдэлийг бууруулахад юу хэрэгтэй вэ?	Бодлогоор зохицуулах; Хувийн бэлтгэлтэй байх; Өвс тэжээлээ бэлтгэх; Бэлчээрийг зохистой ашиглах.
16	УАӨ-ийн асуудлаар МУ-ын бодлого, хууль тогтоомжийн талаар сонссон уу?	Бүгд “Мэдэхгүй” гэж хариулсан.
17	УАӨ-ийн тухай МУ-ын бодлого, зохицуулалтын тухай мэдээлэл авах хэрэгцээ байна уу?	Бүгд “Тийм”

18	УАӨ-ийг бууруулах, дасан зохицох талаар Таны ойлголт хэр зэрэг вэ?	Бүгд “Дунд зэрэг”
19	УАӨ-д дасан зохицох төрийн бодлого, зохицуулалт амьдралд үр дүнгээ өгч байна уу?	Нийтлэг хариулт: “Мэдэхгүй”
20	УАӨ-д дасан зохицоход Та юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?	Нийтлэг хариулт: Төрийн бодлого, зохицуулалтын талаар мэдээлэлтэй болох. Орон нутгийн албан тушаалтнаас зөвлөгөө авах. ТББ, ИНБ-тай холбогдож зөвлөгөө авах. Орон нутгийн иргэдийн хамтын санаачилгад нэгдэх. Малчид, иргэд рүү мэдээлэл өгөх. Нутгийнхны хэрэгцээ, нөөцийн зураглал гаргах. Ургацын даатгалтай болох.

Фокус бүлгийн ярилцлагаас гарсан гол асуудлууд

Фокус бүлгийн ярилцлагаар 2023 оны аадар бороо, үер, 2024 оны зудаас учирсан малын хорогдол, ус, ажиллах хүчний хомсдол малчдын амь нас, амьжиргаанд хэрхэн нөлөөлсөн тухай хэлэлцүүлэг өрнөсөн.

- Усны хомсдол:** Ахмадын бүлгээр өвөлжөөний бэлчээрийг хамгаалах тухай, өвлийн бэлчээрт худаг ухаж гаргасанд шүүмжлэлтэй хандсан. “Сумд өвөлжөөндөө худаг гаргасан. Энэ нь малын бэлчээрийг зөв ашиглахгүй, өвөлжилтөд маш их хортой нөлөөлсөн” гэж 4 дүгээр багийн иргэн, ахмад настан 75 настай Давхайн Дугарсүрэн хэлэв.
- Хүн хүчний дутагдал:** Зудын нөхцөлд айл өрх бүрээс илүү хүч хөдөлмөр шаардагддаг тул ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд эсхүл ганц бие өрх толгойлсон гишүүдтэй өрхүүдэд илүү хүнд тусдаг. Иймээс “Өнгөрсөн өвлийн зудад бид хүн хүчээр дутагдсан. Хот айл болж хөдөлмөрөө хоршихыг зөвлөж байна” гэж 2 дугаар багийн малчин ахмад эмэгтэй Лхасүрэнгийн Борхүүхэн хэлж байв.
- Эмчид үзүүлэх, эмээ авахад гарсан хүндрэл:** Зудын үеэр хүмүүс янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг. Үүний нэг нь эрүүл мэндийн үйлчилгээ, эмээ авахтай холбоотой бэрхшээл юм. Энэ тухай “Өнгөрсөн өвлийн зуданд малаа хорогдуулаад, машин техник ч явж чадахгүй байсан. Энэ үеэр даралт ихсэж, бөөр өвдөж, сэтгэлээр унасан. Багт эмч байдаггүй тул эм тариагаа авахаар сумын төвд ирэхэд заавал эмчийн бичиг хэрэгтэй болсон. Эмийн сангаас эм авахын тулд хурууны хээгээ уншуулдаг зэрэг дарамт нь хүнд байлаа” гэж 4 дүгээр багийн залуу малчин эмэгтэй Гонгорын Хонгорзул ярьж байв.
- Малаа алдах:** 2024 оны зуднаар олон өрх малаа алдсан. “Өнгөрсөн өвлийн цас зуднаар малаа хорогдуулсан. Хүн хүч, техникийн тусалцаа их дутагдсан. Амьжиргааны эх үүсвэрээсээ салчихсан, амьдрал хүнд байна” гэж 1 дүгээр багийн малчин, өрх толгойлсон эмэгтэй С.Цэрэнханд хэлсэн.
- Үерт малаа алдах:** Ширүүн бороо, үер мөн ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. “Аадар борооны үеэр 1 дүгээр багийн залуу малчин өрхийн 110 ямаа нь алга боллоо гэсэн дуудлага өгсөн. Бороо арилснаас хойш 2 хоногийн дараа борооны ус татрах үед тус малчны 110 ямаа нь борооны усанд живж, үхсэн байдалтай олдсон” гэж 3-р багийн Засаг дарга Батсүхийн Ганболд ярьж байлаа.

Ганцаарчилсан ярилцлагын кейс тохиолдлууд:

I. Ахмад эрэгтэй төлөөлөл

- Сумын Багийн Засаг дарга нарт баг бүрдээ нэг үлгэр жишээ болохуйц ажил зохион байгуулах үүрэг өгөх. Тэжээлийн аж ахуй байгуулах хэрэгтэй.

II. Залуу эмэгтэй малчны төлөөлөл

- Сум орон нутгийн бодлогыг мэдэхгүй. Хүн хүч, туулах чадвартай КОВШ техник л хамгийн чухал байна.
- Малын хорогдол их гарч, 1650 толгой малаас 600 толгой малтай үлдэж, 700 сая төгрөгийн хохирол, нөгөө малчин нь 171 сая төгрөгийн хохирол амссан.

III. Залуу эмэгтэй малчны төлөөлөл

- Мал их хорогдсон, эрүүл мэндээрээ ч маш их хохирлоо. 2000 малтайгаас 200 толгой мал үлдсэн. Эмэгтэй хүнд мал маллах нь маш хүнд хөдөлмөр юм байна.
- Сум орон нутаг дундаж амьдралтай хөдөлмөрлөж бүтээж буй малчин эмэгтэйчүүдээ дэмждэггүй.

IV. Орон нутгийн засаг захиргааны эрэгтэй төлөөлөл

- Сум орон нутаг жилдээ өвөлжилт хаваржилтад бэлтгэж, нөөцдөө 30.0–50.0 сая төгрөгийн өвс нөөцөлдөг ч энэ нь сумын нийт малын гуравны нэгд нь л хүрэлцээтэй байдаг. 2023–2024 онд 90,000 толгой мал хорогдсон.

V. Өрх толгойлсон өрхийн эмэгтэй үйлдвэрлэгч

- Ногооны борлуулалт хүнд байдаг. Ногоо даршлах талаар мэдлэгтэй болмоор байна. Бүлэг хамт олноос дэмжлэг үзүүлбэл хамтраад ногооны чиглэлээр хийх ажил их байгаа.

НИЙТИЙН СОНСГОЛ

2024 оны 7 сарын 7-нд Сүхбаатар аймгийн Дарьганга сумд зохион байгуулагдсан нийтийн сонсголд нийт 58 хүн оролцсон.

Нийтийн сонсголыг нээж ХЭХТ-ийн тэргүүн Г.Уранцоож үг хэлэв. Тэрбээр хэлэхдээ:

Судалгааны дүнг хэлэлцэх гэж байна. Энэ хэлэлцүүлгийн үр дүнг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө, концепц, Монгол Улсын үндэсний хэмжээний төлөвлөгөө төсөлд ямар нэгэн байдлаар тусгаж оруулсан байх ёстой. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хоёр чиглэлийн том ажил явагдаж байгаа. Нэг чиглэл нь ногоон хөгжил. Үүнд: уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, арилгах, ногоон хөгжил сэргээгдэх эрчим хүч. Нөгөө чиглэл нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтөөс үүссэн хор хохирлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг бий болгох нь чухал юм.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг дарга Д.Болдбаатар нийтийн сонсголын нээлтэд үг хэллээ

Манай сум “Хүний эрх хөгжил төв” ТББ-тай 10 жилийн өмнөөс хамтран ажиллаж Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийг байгуулсан. Одоогоор олон бүлгүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Төрийн бус байгууллагууд, Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн үйл ажиллагаа төрийн ажлыг нэлээд хөнгөвчилж өгдөг сайн талтай. Уур амьсгалын өөрчлөлт юунаас болоод байна, энэ талаар ярилцахгүй бол хангай дэлхий хүмүүст захирагдахгүй. Тийм учраас бүлгийн гишүүд өөрсдөө судалгаа хийж, бодит мэдээллийг гаргаж байгаа нь маш чухал цаг үеэ олсон ажил болж байна. Хэлэлцүүлэгт нь амжилт хүсье.

Дүгнэлт

Судалгааны асуулга, фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаас дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хохирол, хор уршгийн нөхөн төлбөр авдаггүй, хэнд хандахаа мэддэггүй, мэдээллээр дутмаг. Малын эрсдэлээс хамгаалах даатгал нь сумын нийт малын 6 % нь хорогдсон тохиолдолд нөхөн олговор олгогддог тул энэ нь малчдад хүртээмжгүй. Уур амьсгалын өөрчлөлтөөс учирсан байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх цаг агаарын мэдээг тогтмол сонсож, өвс, хадлан тэжээл, хашаа хороогоо бэлдэж, малаа вакцинжуулж, тэжээж тордон, хувийн бэлтгэлээ сайн хангасан ч байгалийн аюулт үзэгдлийн өмнө малчид хүч мөхөсдөж байна. Иймд малчид руу чиглэсэн төрийн бодлого, зохицуулалт, малчдаа дэмжсэн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатайгаас гадна уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй малчдад учирсан хохирлыг нөхөн олгох, малжуулах, малын үүлдэр угсааг сайжруулах зайлшгүй хэрэгтэй. Түүнчлэн залгамж халаа малчдыг бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх нь чухал юм.



Нийтийн сонсголын үеэр



Д.Болдбаатар
Дарьганга сумын Засаг дарга



Д.Мөнхзул
судалгааны багийн ахлагч,
МХБХ-ын дарга



Нийтийн сонсгол, Сүхбаатар аймгийн Дарьганга сум 2024 оны 07-р сарын 07



Зөвлөмжийг Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Судалгааны багийн хамт олноор ахлуулсан судалгааны үр дүнд үндэслэн боловсруулав.

I. Орон нутгийн засаг захиргаанд:

- Дараа жилийн өвөлжилт хаваржилтад одооноос эхлэн бэлтгэж, малчид, орон нутгийн засаг захиргаа хамтран ажиллах.
- Бизнесийн хадланг гаргахгүй байхыг анхаарч, зохих арга хэмжээг авч, ил тод мэдээллэх.
- Бэлчээрийг зүй зохистой ашиглуулах, эзэмшүүлэх асуудлыг бодлогоор зохицуулах.
- Гамшгаас хамгаалах “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичигт тодотгол хийх.
- Малчдын хохирлыг барагдуулах талаар судлан, малчдад хариу өгөх.
- Туулах чадвартай техникийг худалдан авах. Өвөлжилтийн бэлтгэл хангахдаа шатахууныг нөөцлөх.
- Малчин эмэгтэйчүүдийг сувилалд амрааж, эрүүл мэндэд нь онцгой анхаарах.
- Монгол Улсын шинээр гарсан малчны нийгмийн хамгааллын талаарх хуулиудыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэхэд орон нутгийн засаг захиргаа онцгой анхаарах.

II. Малчдад:

- Өвөлжилтийн бэлтгэлээ сайн хангах.
- Хот айлын зарчмаар нэгдэж хөдөлмөрөө хорших.
- Малын тоо толгойг өсгөхөөс илүү малын чанар, үүлдэг угсааг сайжруулахад төр засагтай хамтрах.

III. Эрүүл мэндийн байгууллагад:

- Цаг хүндэрсэн нөхцөлд малчдад буюу иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээний дарамтыг гаргахгүй байхын тулд тухайн нөхцөлд нь тохирсон арга хэмжээг шуурхай авах. Жишээ нь: Хурууны хээгээр эм олгодог байдлыг түр зогсоох гэх мэт.
- Багийн төвд хүний эмчийг байршуулан ажиллуулах.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААНЫ ӨМНӨ:

Хоёр судалгааны багийн ахлагчид олон улсын судалгааны чадвар хөгжүүлэх сургалтад суусан. 2023 онд Судалгааны багийн ахлагч Я.Мөнхзул Киргиз Улсын Бишкек хот, Д.Мөнхзул, У.Мандхайцэцэн нар Кени Улсын Найроби хотод тус тус сургалтад хамрагдав.



Кени Улсын Накуру тосгон



Иргэд манлайлсан судалгаа, сургалт Киргиз Улсын Бишкек хот

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ИРГЭД МАНЛАЙЛСАН СУДАЛГААНЫ ДАРАА

Гурван судалгааны багийн ахлагчид судалгааны дүнгээр Улаанбаатар хотод 2024 оны 10 сарын 1–2-нд болсон Хүний эрх Хамгаалагчдын Үндэсний 6 дугаар Зөвлөлдөх Уулзалтын “Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас малчдад учирч буй хохирол, хор уршиг” сэдэвт панел хэлэлцүүлэгт илтгэл тавьсан. Үүний үр дүнд судалгааны дүгнэлт, зөвлөмжүүд зохих хэлбэрээр уулзалтын баримт бичигт тусгалаа олж 2024 оны 12 сарын сүүлээр болсон УИХ-ын Хүний эрхийн Дэд Хорооны гишүүдтэй хийсэн уулзалтад танилцуулагдсан болно. Энэ уулзалтад МУ-ын ЗГ-ын Хэрэг Эрхлэх Газрын Төрийн бүтээмжийн Үндэсний Хорооны нарийн бичгийн дарга, хүний эрхийн асуудал хариуцсан ажилтан сууж мэдээлэл авсан.



УАӨ-ийн өөрчлөлтөөс гарсан малчдад учирч буй хохирол, хор уршиг” сэдэвт панел хэлэлцүүлэгт оролцов



Хүний эрх хөгжил төвийн харьяа бүлгийн гишүүд



Хүний эрх Хамгаалагчдын Үндэсний 6 дугаар Зөвлөлдөх уулзалт
Улаанбаатар, 2024 оны 10 сарын 1–2-нд